



2025

**Нийслэлийн өмчит үйлдвэрийн
газруудын бүтээмжийг сайжруулах
судалгаа хийх, төлөвлөлтийн
зураглал гаргах**

СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

“Дижитал оракл монголиа” ХХК

1.ОРШИЛ

Бодит байдал

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн.

Төрийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн **14.1.Төрийн үйлчилгээний албан тушаалд** төрийн үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг бүхий хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллах дараахь албан тушаал хамаарна: **14.1.2.боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, урлаг, спорт зэрэг төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын дарга, захирал, эрхлэгч, бусад удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаал;** хамаарна гэж заасан. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд **“Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд гэнэ. Төрийн өмчит хуулийн этгээдийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь 1/ төрийн байгууллага, албан газар; 2/ төрийн өмчит үйлдвэрийн газар 3/төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг 4/төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага /сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсрол/ гэж ангилна. Хуулийн 15 дугаар зүйлд Төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэгт дан ганц төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орох бөгөөд тэдгээрийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж ангилна: Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ. Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ.** гэж заасан.

Нийслэлийн дараах байгууллагууд “нийслэлийн өмчит төсөвт байгууллага”-ын статустай, дээрх хуулийн зохицуулалтын дагуу улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн тодорхой үйлчилгээг хүргэдэг, ашиг орлого олох боломж хязгаарлагдмал байгаагаас улсын төсөвт ачаалал үүсгэх, ашиггүй, алдагдалтай ажиллах, хөгжих, хөгжүүлэх чиглэлд санал санаачлагагүй ажиллах зэрэг асуудлууд их байна. Өнөөгийн нөхцөлд соёл урлаг тухайн улсын үндэсний дархлаа, үнэт зүйл болохынхоо хувьд, орчин үеийн залуучуудын соёл урлагт хандах хандлага өөрчлөгдсөнтэй

холбоотойгоор төрийн соёлын байгууллагууд өөрчлөгдөх, тохируулан хувьсан өөрчлөгдөх, хөрвөх чадвартай байх зэрэг шаардлага үүссэн учир өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, төр, хувийн хэвшлийн түншлэлийг нэвтрүүлэх, бий болгох зайлшгүй шаардлагатай байна. Улс орны хөгжлийг хөдөлгөгч гол хөшүүрэг нь ТҮНШЛЭЛ бөгөөд төр, хувийн хэвшлийн зохистой хэлбэрийг нэвтрүүлэх чиглэлээр Монгол Улсын хууль эрх зүйн орчинд ямар боломж байгаа, ямар зохицуулалтыг өөрчлөх шаардлагатай талаар гаргалаа.

Эх сурвалж:

Нэг. Хуулиуд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Иргэний хууль
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Төсвийн тухай хууль;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль;
- Хууль тогтоомжийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Олон улсын гэрээний тухай хууль;
- Инновацийн тухай хууль;
- Оюуны өмчийн тухай хууль;
- Зохиогчийн эрхийн тухай хууль;
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Төрийн болон албаны нууцын тухай хууль
- Компанийн тухай хууль

Хоёр. Монгол Улсын Их Хурлын тогтоол:

- 2020 оны №52, “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”

- 2021 оны №106, “Шинэ сэргэлтийн бодлого”
- 2020 оны №23, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр
- 2024 оны №21 Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- 2024 оны №35, Монгол Улсын 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө

Гурав. Засгийн газрын тогтоол:

- 2023 оны №404, “Журам, жишиг баримт бичиг, гэрээний загвар, аргачлал батлах тухай” “Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам”, “Хувийн хэвшлийн түншлэгчийг болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам, жишиг баримт бичиг”, “Түншлэлийн гэрээ байгуулах журам, гэрээний стандарт загвар, гэрээний иж бүрдэл баримт бичиг”, “Түншлэлийн хүрээнд эрсдэл тооцоолох, хуваарилах аргачлал”, “Түншлэлийн төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон хяналт тавих журам”
- 2023 оны №25, “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”

Дөрөв. Нийслэлийн шийдвэрүүд

- НИТХ-ын тогтоол, 2020 оны №02/09, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- НИТХ-ын тогтоол, 2024 оны №24/08, Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- НИТХ-ын тогтоол, 2024 оны №134, Нийслэлийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө

Тав. Бусад шийдвэрүүд:

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/55 дугаар тушаалын 11 дүгээр хавсралт “Хуулийн этгээдийн хэлбэрийн индекс”
-



А.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн нийслэл хэрэгжүүлж байгаа сайн жишээг нэвтрүүлэх:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 26/09 дүгээр тогтоолоор “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК-ийг 100% хувьцаа эзэмшигч байхаар хувьцаа эзэмшигчийн шийдвэр хэлбэрээр үүсгэн байгуулсан. Уг корпораци нийслэлийн бонд гаргах, гадаад дотоодын хөрөнгө оруулагч нартай түншлэл үүсгэх, хөрөнгийн зах зээл дээр арилжаа хийж хөрөнгө оруулалт татах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар нийслэлийн бүтээн байгуулалт хийх зорилгоор хаалттай хувьцаат компанийн хэлбэрээр байгуулагдсан.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны тогтоолоор “Улаанбаатар хотын эдийн засгийн хөгжлийн стратеги”-ийг баталж, уг стратегид хот зөвхөн улс, орон нутгийн төсвөөр хөгжил, бүтээн байгуулалт ярих боломжгүй, өндөр хөгжилтэй хотуудын туршлага нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр буюу харилцан ашигтай хамтын ажиллагааны үндсэн дээр хөгжсэн түүхтэй, энэ жишгийн дагуу нийслэл корпорацийн зарчмаар түншлэлийн сайн хэлбэрийг бүрдүүлэхээр “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК-ийг үүсгэн байгуулж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар нийслэл бүтээн байгуулалт хийх нөхцөлийг бүрдүүлсэн.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхлэхээс өмнө тусгай зориулалтын компани хамтран

байгуулж түншлэл үүсгэж байсан кейсийн түншлэл загвар, батлан гаргасан эрх зүйн баримт бичиг, шийдвэрийн мэдээллийг орууллаа.




Энэ зорилгоо биелүүлж, төр хувийн хэвшлийн түншлэлээр 10 орчим төслийн нэгжийг хамтарсан тусгай зориулалтын компани хэлбэрээр үүсгэн байгуулсан. Түншлэлийн энэ хэлбэрийн давуу тал нь:

1. Төр, хувийн хэвшил хоёр харилцан тэгш эрх эдэлж, үүрэг хариуцлага хүлээдэг.
2. Хувийн хэвшил итгэл үнэмшилтэйгээр өөрийн хөрөнгө оруулалтыг хийдэг.
3. Хяналт тавих механизмийн сайн загвар болдог.
4. Бараа, ажил, үйлчилгээгээ хамтран гүйцэтгэдэг.
5. Хариуцлага хамтран хүлээдэг.
6. Эрсдэл хуваарилах шударга институт хэрэгждэг.
7. Урт хугацааны гэрээ байгуулдаг.
8. Төрийн бодлого, хэрэгжүүлэлт гүйцэтгэгддэг.
9. Нийгмийн хөгжилд иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн оролцоо хангагддаг.
10. Хот төлөвлөлт, эдийн засгийн өсөлтөд шууд нөлөө үзүүлдэг.
11. Дэд бүтэц, нийгмийн үйлчилгээг иргэдэд хүргэх хамгийн ойр арга зам болдог
12. Үнэ-чанарын харьцаа, эдийн засгийн үр ашиг хамгийн зөв байх хувилбараар хэрэгждэг.


Түншлэлийн хэлбэр буюу бизнес загвар тухайн төслийн чиглэл, зорилго, хөрөнгө оруулагчийн санал, түншлэлийн хэлбэр, ашиг орлого олох нөхцөлөөс шалтгаалан өөр өөр байдаг ч ерөнхий нэг зарчим нь хувийн хэвшил хөрөнгөө оруулах, нийслэл нь төрийн

үйлчилгээг хувийн хэвшилд шилжүүлэх, шаардлагатай тохиолдолд газар, лиценз, зөвшөөрлийг хариуцах, бодлогын түвшинд хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх үүргийг хүлээж, түншлэлийг бий болгодог.

Түншлэлийн хэлбэрүүдийн жишээ:




Зураг 1. Ажиллагчдын орон тоон мэдээлэл, байгууллагаар, 2024 он




Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах хоёр дахь төслийг удирдах нэгж батлагдсан орон тоонд 100 хувьд хүрч ажиллаж байгаа бол Орон Сууц нийтийн аж ахуйн удирдах газар одоо ажиллаж байгаа 1,966 буюу батлагдсан орон тооны 97.4 хувь, Улаанбаатар хотын Ус сувгийн Удирдах газар одоо ажиллаж байгаа 1,775 буюу батлагдсан орон тооны 94.3 хувь, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар одоо ажиллаж байгаа 668 буюу батлагдсан орон тооны 70.5 хувь, Геодези, усны барилга, байгууламжийн газар одоо ажиллаж байгаа 120 буюу батлагдсан орон тооны 86.3 хувь, Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК одоо ажиллаж байгаа 17 буюу батлагдсан орон тооны 25.4 хувь байна.

Зураг 2. Батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл, байгууллагаар (сая.төг) 2024 он



Дэд бүтцийн корпорацийн нийт батлагдсан төсөв 291,440.2 сая төгрөг байна. Үүнээс Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах хоёр дахь төслийг удирдах нэгж 125.6 сая төгрөг буюу 0.04 хувь, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар 9,570.9 сая төгрөг буюу 3.3 хувь, Геодези, усны барилга, байгууламжийн газар 15,159.5 сая төгрөг буюу 5.2 хувь, Ус сувгийн Удирдах газар 127,144.4 сая төгрөг буюу 43.6 хувь, Орон Сууц нийтийн аж ахуйн удирдах газар 139,439.8 сая төгрөг буюу 47.8 хувийг бүрдүүлж байна.

Зураг 3. Нийт хөрөнгө болон өр төлбөрийн дүн, байгууллагаар (сая.төг) 2024 он



Дэд бүтцийн корпорацийн нийт хөрөнгийн дүн 800,382.1 сая төгрөг ба үүнээс өр төлбөр 120,540.9 сая төгрөг цэвэр хөрөнгийн өмч нь 679,841.2 сая төгрөг байна.

Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах хоёр дахь төслийг удирдах нэгжийн нийт хөрөнгө 766.8 сая төгрөг буюу 2024 онд өр төлбөргүй байна. Мөн Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК 2025 оны 01 дүгээр сард байгуулагдсан тул өр төлбөргүй байна.

Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газрын нийт хөрөнгө 40,039.3 сая төгрөг үүнээс 71.9 хувь нь (28,799.1 сая.төг) өр төлбөр ба нийт цэвэр хөрөнгийн өмч нь 11,240.2 сая төгрөг байна.

Геодези, усны барилга, байгууламжийн газрын нийт хөрөнгө 81,406.4 сая төгрөг үүнээс 28.2 хувь нь (22,966.5 сая.төг) өр төлбөр ба нийт цэвэр хөрөнгийн өмч нь 58,439.9 сая төгрөг байна.

Орон Сууц нийтийн аж ахуйн удирдах газрын нийт хөрөнгө 181,815.2 сая төгрөг үүнээс 36.1 хувь нь (65,685.5 сая.төг) өр төлбөр ба нийт цэвэр хөрөнгийн өмч нь 116,129.8 сая төгрөг байна.


Улаанбаатар хотын Ус сувгийн Удирдах газрын нийт хөрөнгө 496,354.4 сая төгрөг үүнээс 0.6 хувь нь (3,089.9 сая.төг) өр төлбөр ба нийт цэвэр хөрөнгийн өмч нь 493,264.5 сая төгрөг байна.

УЛААНБААТАР ХОТЫН ТЭЭВРИЙН КОРПОРАЦИ

Тээврийн корпорацид хамаарах 10 байгууллага байна. Үүний 6 нь өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, 2 нь өмчит үйлдвэрийн газар, 1 нь төслийн нэгж, 1 нь хариуцлагатай компани байна. Үүнд:


- I. Зорчигч тээвэр нэг
- II. Зорчигч тээвэр хоёр
- III. Зорчигч тээвэр гурав
- IV. Зорчигч тээвэр дөрөв
- V. Зорчигч тээвэр тав
- VI. Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын төв ОНӨААТҮ
- VII. Нийслэлийн Замын хөдөлгөөний удирдлагын төв
- VIII. Нийслэлийн Төр захиргааны Авто бааз УТҮГ
- IX. Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төсөл
- X. Олон улсын худалдаа логистикийн төв ХК

Зураг 4. Тээврийн корпорацийн орон тоон мэдээлэл




Тээврийн корпорацид хамаарах нийт 10 байгууллагын батлагдсан орон тоо 2,624 байгаагаас одоо ажиллаж байгаа 2,216 үүнээс хэмнэсэн 408 ажиллагчдын орон тоо байна. Нийт батлагдсан орон тооны 84.5 хувь нь одоо ажиллаж байгаа бол 15.5 хувийн сул орон тоо байна.

Зураг 5. Ажиллагчдын орон тоон мэдээлэл, байгууллагаар, 2024 он



Зорчигч тээвэр дөрөв, Нийслэлийн Төр захиргааны Авто бааз УТҮГ болон Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээ батлагдсан орон тоонд 100 хувьд хүрч ажиллаж байгаа бол Олон улсын худалдаа логистикийн төв ХК одоо ажиллаж байгаа 47 буюу батлагдсан орон тооны 97.9 хувь, Нийслэлийн Замын хөдөлгөөний удирдлагын төв одоо ажиллаж байгаа 94 буюу батлагдсан орон тооны 90.4 хувь, Зорчигч тээвэр гурав одоо ажиллаж байгаа 573 буюу батлагдсан орон тооны 62.5 хувь, Зорчигч тээвэр тав одоо ажиллаж байгаа 591 буюу батлагдсан орон тооны 77.7 хувь, Зорчигч тээвэр хоёр одоо ажиллаж байгаа 846 буюу батлагдсан орон тооны 94.0 хувь байна.

Зураг 6. Батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл, байгууллагаар (сая.төг) 2024 он



Тээврийн корпорацийн нийт батлагдсан төсөв 150,441.5 сая төгрөг байна. Үүнээс Нийслэлийн Замын хөдөлгөөний удирдлагын төв 2,690.4 сая төгрөг буюу 1.8 хувь, Олон улсын худалдаа логистикийн төв ХК 2,696.3 сая төгрөг буюу 1.8 хувь, Нийслэлийн Төр захиргааны Авто бааз УТҮГ 3,391.3 сая төгрөг буюу 2.3 хувь, Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төсөл 6,361.1 сая төгрөг буюу 4.2 хувь, Зорчигч тээвэр дөрөв 7,441.0 сая төгрөг буюу 4.9 хувь, Зорчигч тээвэр тав 14,845.4 сая төгрөг буюу 9.9 хувь, Зорчигч тээвэр хоёр 26,411.6 сая төгрөг буюу 17.6 хувь, Зорчигч тээвэр нэг 33,153.0 сая төгрөг буюу 22.0 хувь, Зорчигч тээвэр гурав 53,451.4 сая төгрөг буюу 35.5 хувийг бүрдүүлж байна.

Зорчигч тээвэр нэг болон Зорчигч тээвэр хоёр нь 2024 онд, Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын төв нь 2025 онд байгуулагдсан байна.

Зураг 7. Нийт хөрөнгө болон өр төлбөрийн дүн, байгууллагаар (сая.төг) 2024 он



Тээврийн корпорацийн нийт хөрөнгийн дүн 258,080.5 сая төгрөг ба үүнээс өр төлбөр 113,554.8 сая төгрөг цэвэр хөрөнгийн өмч нь 144,525.7 сая төгрөг байна.

Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төслийн нийт хөрөнгө 36.0 сая төгрөг ба 2024 онд өр төлбөргүй байна.

Нийслэлийн Төр захиргааны Авто бааз УТҮГ нийт хөрөнгө 3,250.8 сая төгрөг үүнээс 30.0 хувь нь (976.8 сая.төг) өр төлбөр ба нийт цэвэр хөрөнгийн өмч нь 2,274.0 сая төгрөг байна.

Нийслэлийн Замын хөдөлгөөний удирдлагын төвийн нийт хөрөнгө 4,672.1 сая төгрөг үүнээс 2.1 хувь нь (99.0 сая.төг) өр төлбөр ба нийт цэвэр хөрөнгийн өмч нь 4,573.1 сая төгрөг байна.

Зорчигч тээвэр гуравын нийт хөрөнгө 56,277.4 сая төгрөг үүнээс 104.3 хувь нь (58,724.8 сая.төг) өр төлбөр ба нийт цэвэр хөрөнгийн өмч нь -2,447.4 сая төгрөг байна.

Зорчигч тээвэр тавын нийт хөрөнгө 57,441.5 сая төгрөг үүнээс 14.4 хувь нь (8,273.1 сая.төг) өр төлбөр ба нийт цэвэр хөрөнгийн өмч нь 49,168.4 сая төгрөг байна.

Олон улсын худалдаа логистикийн төв ХК-ийн нийт хөрөнгө 60,522.8 сая төгрөг үүнээс 2.1 хувь нь (1,255.4 сая.төг) өр төлбөр ба нийт цэвэр хөрөнгийн өмч нь 59,267.4 сая төгрөг байна.


Зорчигч тээвэр хоёрын нийт хөрөнгө 75,879.9 сая төгрөг үүнээс 58.3 хувь нь (44,225.8 сая.төг) өр төлбөр ба нийт цэвэр хөрөнгийн өмч нь 31,654.1 сая төгрөг

байна.УЛААНБААТАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, МЕНЕЖМЕНТ ҮНЭТ ЦААСНЫ КОРПОРАЦИ

Хөрөнгө оруулалт, менежмент үнэт цаасны корпорацид хамаарах 2 байгууллага байна. Үүнд:


- I. Нийслэлийн Бизнес инновацийн газар
- II. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар

Зураг 8. Хөрөнгө оруулалт, менежмент үнэт цаасны корпорацийн орон тоон мэдээлэл




Хөрөнгө оруулалт, менежмент үнэт цаасны корпорацид хамаарах нийт 2 байгууллагын батлагдсан орон тоо 127 байгаагаас одоо ажиллаж байгаа 124 үүнээс хэмнэсэн 3 ажиллагчдын орон тоо байна. Нийт батлагдсан орон тооны 97.6 хувь нь одоо ажиллаж байгаа бол 2.4 хувийн сул орон тоо байна.

Зураг 9. Батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл, байгууллагаар (сая.төг) 2024 он



Хөрөнгө оруулалт, менежмент үнэт цаасны корпорацийн нийт батлагдсан төсөв 7,034.0 сая төгрөг байна. Бизнес инновацын газар 679.1 сая төгрөг буюу 9.7 хувь, Хөрөнгө оруулалтын газар 6,354.8 сая төгрөг буюу 90.3 хувийг бүрдүүлж байна.

Зураг 10. Нийт хөрөнгө болон өр төлбөрийн дүн, байгууллагаар (сая.төг) 2024 он



Хөрөнгө оруулалт, менежмент үнэт цаасны корпорацийн нийт хөрөнгийн дүн 522,117.9 сая төгрөг ба үүнээс өр төлбөр 53,568.0 сая төгрөг цэвэр хөрөнгийн өмч нь 468,550.0 сая төгрөг байна.

Нийслэлийн Бизнес инновацын газрын нийт хөрөнгө 4,908.8 сая төгрөг ба 2024 онд өр төлбөргүй байна.

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын нийт хөрөнгө 517,209.1 сая төгрөг үүнээс 10.4 хувь нь (53,568.0 сая.төг) өр төлбөр ба нийт цэвэр хөрөнгийн өмч нь 463,641.1 сая төгрөг байна.

Нийслэлийн харьяа байгууллагуудыг корпорацийн тогтолцоонд шилжүүлж, түүнийг удирдах

Байгууллагуудыг корпорацийн бүтцэд шилжүүлж, түүний үйл ажиллагааг удирдахдаа KPI (гүйцэтгэлийн үнэлгээний менежментийн) аргыг ашиглах бөгөөд байгууллагын зорилгод хүрэхэд чухал ач холбогдолтой гүйцэтгэлийн хэмжүүрүүдийг тодорхойлж, тэдгээрийн хэмжүүрийн гол шалгуур үзүүлэлт нь хотын хөгжлийн индекс юм. Түүнчлэн эдгээр корпораци бүрийг хэрэгжүүлэх төсөл гэж үзэн CPI буюу зардлын гүйцэтгэлийн индекс, SPI буюу хуваарийн гүйцэтгэлийн индекс зэрэг үзүүлэлтүүдийг хамт тооцох нь чухал юм.

Тухайлбал, Орон сууцны корпорацид орсон байгууллагууд нь 3 индекс (орон сууцны хүртээмж, амьдрах орчны нөхцөл, хүлэмжийн хий багатай эрчим хүчний үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт) хамааралтай байгаа бөгөөд одоогийн байгаа түвшнээрээ **0.287** байна. Эдгээр байгууллагуудыг корпорацийн бүтцэд шилжүүлсэнээр 2030 онд индексийн утга **0.415** болж сайнаар нөлөөлөхөөр байна.

Зураг 11. Улаанбаатар хотын орон сууцны корпорацитай хамаарагдах индекс



Зураг 12. Орон сууцны корпорацид хамаарах 5 байгууллагаар хамаарагдах индекс

